



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 12/2293

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид барилга байгууламж,
эд хөрөнгө бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 114 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банкт байгуулсан “Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр”-ийн дагуу хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр баригдаж, ашиглалтад орсон нийт 16,513,749,617.20 (арван зургаан тэрбум таван зуун арван гурван сая долоон зуун дөчин есөн мянга зургаан зуун арван долоон төгрөг хорин мөнгө) төгрөгийн өртөг бүхий хавсралтад заасан барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Энэ захирамжийн 1-д заасан барилга байгууламж, тоног төхөөрөмжийг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205585



Нийслэлийн Засаг даргын 2024 оны
11 дугаар сарын 04-ны өдрийн
А/1293 дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

(төгрөгөөр)

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх дүн /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1	Сэлбэ дэд төвийн 2 дугаар хэлхээ болон 960 хүүхдийн сургууль 1-р хэлхээ УДДТ12-с 2-р хэлхээний дулаан хангамж, хэрэглээний халуун ус, цэвэр усны шугам сүлжээний ажил, 1ш УДДТ-ийн барилга	Сүхбаатар 13, 14-р хороо, Чингэлтэй дүүргийн 18-р хороо	2021, 2022	4,189,631,201.93	Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банктай байгуулсан "Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр"-ийн дагуу ЕХОБ-ны хөнгөлөлтэй зээлийн санхүүжилт	"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ
2	Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсийн усан сан, насос станцын барилга, шугам сүлжээ	Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо	2023	12,324,118,415.38		Ус Сувгийн Удирдах Газар ОНӨААТҮГ
НИЙТ ДҮН				16,513,749,617.31		